



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/166/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: [b.dagvaa1000@gmail.com](mailto:b.dagvaa1000@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	<a href="#">4</a>
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<a href="#">5</a>
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	<a href="#">6</a>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	<a href="#">7</a>
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

---

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Уластай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.14 № 133

тантай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэс сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тэс сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тэс сумын цэцэрлэгт Боловсрол Шинжлэх ухааны яам, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар ирсэн 222,028.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, мөн заставын цэцэрлэгийн газрыг бүртгэлжүүлж гэрчилгээжүүлэн 12,490.0 мянган төгрөгөөр үнэлж, данс бүртгэлд тусгасан байна. Элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн 83 нэр төрлийн 710,340.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгахаар байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр хэлэлцэн холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Тэс сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Тэс сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 98.5 хувьтай үнэлэгдсэн байна. Тус цэцэрлэг нь тайлант онд 22 орон тоотой, 359,423.7 мянган төгрөгийн санхүүжилттэй, 789,412.1 мянган төгрөгийн зарцуулалттай, 70,011.6 мянган төгрөгийн хэмнэлттэй

D:/disk/Албан бичиг/Дүгнэлт

ажилласан бөгөөд 381.3 мянган төгрөгийн авлагатай, 5,179.8 мянган төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

  
Д БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	214,696,826.93	270,902,910.61
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	112,445,583.49	134,537,564.23
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	112,445,583.49	134,537,564.23
3121	Төгрөг	112,445,583.49	134,537,564.23
31211	Төрийн сангийн харилцах	112,445,583.49	134,537,564.23
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	(0.00)	(0.00)
33	АВЛАГА	423,999.09	381,278.77
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	423,999.09	381,278.77
35	БАРАА МАТЕРИАЛ	101,827,244.35	135,984,067.61
351	Түүхий эд материал	280,000.00	280,000.00
35130	Эм боох материал	280,000.00	280,000.00
354	Хангамжийн материал	101,521,244.35	135,704,067.61
35410	Бичиг хэргийн материал	406,850.00	2,376,920.00
35420	Аж ахуйн материал	4,057,500.00	3,689,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	280,000.00	140,000.00
35440	Түлш шатах тослох материал	5,563,975.00	4,321,915.00
35450	Барилгын засварын материал	750,000.00	750,000.00
35460	Хүнсний материал	1,639,000.00	427,350.00
35470	Бусад хангамжийн материал	88,823,919.35	123,998,882.61
35600	Мал, амьтад	26,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	588,219,926.40	774,057,045.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	588,219,926.40	774,057,045.13
392	Биет хөрөнгө	580,790,051.40	754,309,045.13
39201	Барилга, байгууламж	359,174,299.04	359,174,299.04
39202	Хуримтлагдсан элэгдэл	(55,653,875.58)	(67,343,440.38)
39205	Машин, тоног төхөөрөмж	79,489,421.00	234,181,395.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,076,235.13)	(67,513,620.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,303,252.80	95,639,732.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,729,715.17)	(23,483,054.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	270,636,825.00	270,636,825.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(32,278,419.72)	(48,907,591.44)
39217	Номын фонд	1,924,499.16	1,924,499.16
393	Биет бус хөрөнгө	7,429,875.00	19,748,000.00
39301	Програм хангамж	1,850,000.00	1,850,000.00
39302	Хасагдуулга	(1,678,125.00)	(1,850,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,258,000.00	19,748,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	802,916,753.33	1,044,959,955.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	5,179,799.17
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	5,179,799.17
413	Өглөг	0.00	5,179,799.17
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	46,816.77
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	(0.00)	5,132,982.40
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	802,916,753.33	1,039,780,156.57
51	Засгийн газрын хувь оролцоо	802,916,753.33	1,039,780,156.57
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	104,016,740.00	104,016,740.00
51101	Өмч: -Төрийн өмч	104,016,740.00	104,016,740.00
512	Хуримтлагдсан үр дүн	349,081,634.79	585,945,038.03
51210	Өмнөх үеийн үр дүн	349,081,634.79	349,081,634.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	236,863,403.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	349,818,378.54	349,818,378.54

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	802,916,753.33	1,044,959,955.74
---	-------------------------------------	----------------	------------------

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	690,666,547.35	1,056,671,752.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	49,409,447.35	267,259,652.75
120	Нийтлэг татварын бус орлого	49,409,447.35	267,259,652.75
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	49,409,447.35	267,259,652.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,536,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	47,873,447.35	267,259,652.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	641,257,100.00	789,412,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	582,586,100.00	740,135,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	582,586,100.00	740,135,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	48,671,000.00	49,276,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,671,000.00	49,276,200.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	10,000,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	10,000,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	592,332,478.06	819,808,349.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	592,332,478.06	819,808,349.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	583,914,526.96	818,259,652.36
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	364,494,805.14	558,361,232.76
210101	Цалин	250,296,752.33	558,361,232.76
210102	Нэмэгдэл цалин	96,033,440.26	-
210104	Урамшуулал	18,164,612.55	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,186,647.48	70,539,733.49
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,246,800.45	48,441,492.54
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,941,030.56	5,579,199.51
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,936,288.99	2,845,921.44
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	721,804.94	2,693,005.50
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,340,722.54	10,980,114.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,354,463.90	52,095,570.85
210301	Гэрэл цахилгааны зардал	3,858,678.90	3,776,912.85
210302	Түлш, халаалтын зардал	37,495,785.00	48,318,658.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,830,295.11	13,904,539.50
210401	Бичиг хэргийн материал	4,382,600.00	7,867,380.00
210402	Тээвэр, шатахууны зардал	2,077,373.10	3,777,559.50
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,594,600.00	2,233,600.00
210408	Бараа материал актасны зардал	9,775,722.01	26,000.00
2105	Нормативт зардал	57,915,225.00	67,203,840.00
210501	Эм	1,455,500.00	1,453,000.00
210502	Хоол	56,459,725.00	65,750,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,250,000.00	2,139,900.00
210604	Урсгал засвар	11,250,000.00	2,139,900.00
2107	Томилолт, зочны зардал	773,000.00	-
210702	Дотоод томилолтын зардал	773,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	4,649,250.00	4,591,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,349,250.00	3,791,500.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,300,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,460,840.33	49,423,335.76

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	742,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,460,840.33	48,681,335.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,417,951.10	1,548,697.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,751,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,751,400.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,666,551.10	1,548,697.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,666,551.10	1,548,697.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	98,334,069.29	236,863,403.24
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	3,761,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,761,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(3,761,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	94,573,069.29	236,863,403.24

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	642,793,100.00	789,412,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,536,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,536,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,536,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,536,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	641,257,100.00	789,412,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	582,586,100.00	740,135,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	582,586,100.00	740,135,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	58,671,000.00	49,276,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	48,671,000.00	49,276,200.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	10,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	550,690,715.04	767,320,119.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550,690,715.04	767,320,119.26
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	542,272,763.94	765,771,422.11
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	364,494,805.14	558,360,473.94
210101	Үндсэн цалин	250,296,752.33	372,141,625.12
210102	Нэмэгдэл	96,033,440.26	161,181,936.32
210104	Үр дүнгийн урамшуулал	18,164,612.55	25,036,912.50
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	48,229,367.80	70,450,955.22
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,289,520.77	48,352,714.27
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,941,030.56	5,579,199.51
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,936,288.99	2,845,921.44
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	721,804.94	2,693,005.50
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,340,722.54	10,980,114.50
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	45,002,848.90	45,726,102.85
210301	Гэрэл цахилгааны зардал	3,858,678.90	3,776,912.85
210302	Түлш, халаалтын зардал	41,144,170.00	41,949,190.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,424,973.10	8,393,335.10
210401	Бичиг хэрэг	2,800,100.00	2,756,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,190,173.10	3,771,985.10
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,434,700.00	1,865,100.00
2105	Норматив зардал	53,089,249.00	65,945,955.00
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,065,500.00	1,453,000.00
210502	Хоол, хүнс	52,023,749.00	64,492,955.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	1,999,900.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	1,999,900.00
2107	Томилолт, зочны зардал	773,000.00	-
210702	Дотоод албан томилолт	773,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,649,250.00	4,591,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,349,250.00	3,791,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,300,000.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,609,270.00	10,303,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,924,870.00	3,222,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	1,684,400.00	7,081,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,417,951.10	1,548,697.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,751,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,751,400.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,666,551.10	1,548,697.15
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,666,551.10	1,548,697.15
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	92,102,384.96	22,091,980.74
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,799,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,799,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	2,799,900.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,799,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,799,900.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	89,302,484.96	22,091,980.74
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,143,098.53	112,445,583.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,445,583.49	134,537,564.23

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	104,016,740.00	349,818,378.54	349,081,634.79	802,916,753.33
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	104,016,740.00	349,818,378.54	349,081,634.79	802,916,753.33
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	104,016,740.00	349,818,378.54	349,081,634.79	802,916,753.33
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-

Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	-	-	236,863,403.24	236,863,403.24
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	104,016,740.00	349,818,378.54	585,945,038.03	1,039,780,156.57

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	112,445,583.49	(112,445,583.49)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	849,704,800.00	718,043,919.26	131,660,880.74	84.51
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	849,704,800.00	718,043,919.26	131,660,880.74	84.51
210	Бараа, үйлчилгээний зардал	849,704,800.00	718,043,919.26	131,660,880.74	84.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	666,310,800.00	558,360,473.94	107,950,326.06	83.80
210101	Үндсэн цалин	438,965,300.00	372,141,625.12	66,823,674.88	84.78
210102	Нэмэгдэл	215,797,800.00	161,181,936.32	54,615,863.68	74.69
210104	Урамшуулал	11,547,700.00	25,036,912.50	(13,489,212.50)	216.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,323,100.00	70,450,955.22	7,872,144.78	89.95
210201	Тэтгэврийн даатгал	53,261,100.00	48,352,714.27	4,908,385.73	90.78
210202	Тэтгэмжийн даатгал	6,264,600.00	5,579,199.51	685,400.49	89.06
210203	ҮОМШӨ ний даатгал	3,132,800.00	2,845,921.44	286,878.56	90.84
210204	Ажилгүйдлийн даатгал	3,132,800.00	2,693,005.50	439,794.50	85.96
210205	Эрүүл мэндийн даатгал	12,531,800.00	10,980,114.50	1,551,685.50	87.62
2104	Хангамж, бараа материалын зардал	-	8,393,335.10	(8,393,335.10)	-
210401	Бичиг хэрэг	-	2,756,250.00	(2,756,250.00)	-
210402	Тээвэр (шатахуун)	-	3,771,985.10	(3,771,985.10)	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	1,865,100.00	(1,865,100.00)	-
2105	Нормативт зардал	74,675,300.00	65,945,955.00	8,729,345.00	88.31
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	-	1,453,000.00	(1,453,000.00)	-
210502	Хоол, хүнс	74,675,300.00	64,492,955.00	10,182,345.00	86.36
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,312,500.00	4,590,000.00	(2,277,500.00)	198.49
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,790,000.00	(3,790,000.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	2,312,500.00	800,000.00	1,512,500.00	34.59
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	28,083,100.00	10,303,200.00	17,779,900.00	36.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,006,400.00	3,222,000.00	17,784,400.00	15.34
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,076,700.00	7,081,200.00	(4,500.00)	100.06
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	810,147,500.00	740,135,900.00	70,011,600.00	91.36
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	700,578,600.00	740,135,900.00	(39,557,300.00)	105.65

131001	Улсын төсвөөс санхүүжих	700,578,600.00	740,135,900.00	(39,557,300.00)	105.65
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	109,568,900.00	-	109,568,900.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	109,568,900.00	-	109,568,900.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	112,445,583.49	(112,445,583.49)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	134,537,564.23	(134,537,564.23)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,276,200.00	49,276,200.00	-	100.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	49,276,200.00	49,276,200.00	-	100.00
210	Бараа, үйлчилгээний зардал	49,276,200.00	47,727,502.85	1,548,697.15	96.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,276,200.00	45,726,102.85	1,550,097.15	96.72
210301	Гэрэл цахилгаан	5,522,500.00	3,776,912.85	1,745,587.15	68.39
210302	Түлш, халаалт	40,753,700.00	41,949,190.00	(1,195,490.00)	102.93
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	-	1,000,000.00	-
2106	Эд хогшил худалдан авах	2,000,000.00	1,999,900.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,999,900.00	100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	1,500.00	(1,500.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,500.00	(1,500.00)	-
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,548,697.15	(1,548,697.15)	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,548,697.15	(1,548,697.15)	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,548,697.15	(1,548,697.15)	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,276,200.00	49,276,200.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,276,200.00	49,276,200.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	49,276,200.00	49,276,200.00	-	100.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### **Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:**

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

##### **Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:**

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 64 арга хэмжээ төлөвлөснөөс 98.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:**

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай”, “цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх” зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 242,043.2 мянган төгрөгөөр буюу 30.1 хувиар өссөн нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлүүд нэмэгдсэнтэй холбоотой байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	112,445.6	134,537.6	22,092.0
Авлага	424.0	381.3	-42.7
Бараа материал	101,827.2	135,984.1	34,156.9
Үндсэн хөрөнгө	588,219.9	774,057.0	185,837.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>802,916.7</b>	<b>1,044,959.9</b>	<b>242,043.2</b>
Өр төлбөрийн дүн	0	5,179.8	5,179.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	802,916.7	1,039,780.1	236,863.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>802,916.7</b>	<b>1,044,959.9</b>	<b>242,043.2</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### Тайлант онд:

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 22,092.0 мянган төгрөгөөр, бараа материал 34,156.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө 185,837.1 мянган төгрөгөөр тус тус өссөн бол авлага дансны эцсийн үлдэгдэл 42.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 101,827.2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 91,687.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч хандив, тусламжаар 32,711.9 мянган төгрөгийн хүнсний болон бусад хангамжийн материал хүлээн авч нийт 124,428.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогот авчээ. Харин 90,245.6 мянган төгрөгийн зарцуулалт хийж, 26.0 мянган төгрөгийн хорогдсон малыг бүртгэлээс хассан байна. Жилийн эцсийн хөрөнгө, бараа материалын тооллогоор 135,984.1 мянган төгрөгийн үлдэгдэл тоологдож, тооцоо бодогдсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 234,518.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэлийг хандив тусламжаар авч, 6245 м.кв газрыг 12,490.0 мянган төгрөгөөр үнэлэн бусад биет бус

хөрөнгийн дансанд бүртгэснээр 774,057.0 мянган төгрөгийн хөрөнгөтэй болжээ. 48,681.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант оны эцэст өмнөх оны авлагыг 42.7 мянган төгрөгөөр бууруулж, тээвэр шатахуун, ндш, түлш халаалтын зардалтай холбоотой 5,179.8 мянган төгрөгийн өглөг үүсгэжээ.

#### **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 849,704.8 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 49,276.2 мянган төгрөгөөр, зардлыг 898,981.0 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 740,135.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 49,279.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлснээс 1,548.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 767,320.1 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байна. Энэ нь цалин хөлсний зардал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хүнсний материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна. Хангамж бараа материалын зардал, эмийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 1,453.0 мянган төгрөгөөс 8,393.3 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

#### **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

<i>/мянган төгрөгөөр/</i>					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	849,704.8	718,043.9	131,660.9	84.5
80233	Хүүхэд хамгааллын зардал	998.2	998.0	0	100
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	1,778.8	1,086.9	691.9	
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	73,427.9	64,493.0	8,934.9	
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,482.2	2,480.0	2.2	
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	1,719.6	1,300.0	419.6	
81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	11,271.2	938.0		
81833	Явуулын багшийн үйлчилгээ				
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	751,769.3	640,490.4		
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	6,257.6	6,257.6	0	100
<b>Дүн</b>		<b>849,704.8</b>	<b>718,043.9</b>	<b>131,660.9</b>	<b>84.5</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		<b>49,276.2</b>	<b>49,276.2</b>	<b>1,548.7</b>	<b>99.99</b>

80109	Тогтмол зардал	50,824.9	49276.2	1.548.7	
	<b>Нийт дүн</b>	<b>900,529.7</b>	<b>767,320.1</b>	<b>133,209.8</b>	<b>85.35</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 49,276.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 45,727.6 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,999.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 1.548.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

#### Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөгөөр/*

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Ганзүр Тэс ХХК тендер шалгаруулалт	Хүнсний болон аж ахуйн материал нийлүүлэх	56,103.4	45,387.4
2	Эл Би Си ХХК шууд гэрээ	халаалт	33,525.4	33,525.4
3	Тэс минж шууд гэрээ	Хоол хүнс, аж ахуйн материал	33,162.3	33,162.3
4	АУЭХС шууд гэрээ	Гэрэл цахилгаан	3,503.9	3,503.9
5	Б. Энхболд шууд гэрээ	Галын мод	8,123.8	8,123.8
<b>ДҮН</b>			<b>134,416.8</b>	<b>123,702.8</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс 1.5 хувиар тооцож, 8,260.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 6,195.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

#### **5.1 Төлбөрийн акт: тогтоогоогүй**

#### **5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

#### **5.3 Зөвлөмж: өгөгдөөгүй**

Аудитын явцад материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул **"Өөрчлөлтгүй"** дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруу-лаагүй	Тоо	Дүн

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын Байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

**ХЯНАСАН:**  
 АХЛАХ АУДИТОР  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-20  
 0971106092

**БОЛОВСРУУЛСАН:**

“ХААН СОЁМБО АУДИТ” ХХК-НИЙ АУДИТОР  
 Огноо: 2025-02-20

Ц.ОЮУНСҮВД  
 Х.БОЛДБААТАР  
 Д.БАТ-УНДРАА

Р.МЯДАГМАА

Үүнээс

/Мянган тэгрөгөөр/

/Мянган тэгрөгөөр/